

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 16-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, "Сүү" ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13.16 дахь хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2023 оны 08 сарын 16-ны өдөр хуралдсан "Сүү" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сүү" ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 2,642,117,608.9 /Хоёр тэр бум зургаан зуун дөчин хоёр сая нэг зуун арван долоон мянга зургаан зуун найман төгрөг есөн мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. "Сүү" ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 7.7 /Долоон төгрөг долоон мөнгө/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг "Сүү" ХК-ийн 2023 оны 09 сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 02 сарын 10-ны өдрийн дотор тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР